

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Эрдэнэбат	Дугаар	L286
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Рашаант сум
Төрсөн газар	Рашаант сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Дашдаржаалин хийдийн тэргүүн лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Рашаантын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨРА 065
Одоогийн сүм хийд	Дашдаржаалин	Сүм хийдийн дугаар	ХӨРА 018
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Рашаант сумын Рашаантын хүрээ, Дашдаржаалин хийд

Мөнхбат:Тэгэхээр танаас дараах хэд хэдэн асуултыг асууя. Тэгэхээр энэ Дашдаржаалин хийд маань мэдээж шинэ цагийн хийд. Энэ хийд маань одоо энэ хавь бүс нутагт алдартай байсан Рашаантын хүрээ буюу Даравбандид Мэргэн гэгээний хүрээг одоо залгамжилж гарч ирсэн нь тодорхой байна, тийм ээ.Тэгэхээр яг хэдэн онд сэргээгдэж ингэж барьсан бэ?

Эрдэнэбат: Наян есөн онд, гэр дугантай байж байгаад. Ерэн гурван оны өвөл, ерэн дөрвөн оны эхээр.

Мөнхбат: Энэ одоо дуган баригдаж?

Эрдэнэбат: Тийм, баригдаж...

Мөнхбат: Байнгын үйл ажиллагаатай болжээ, тийм ээ?

Эрдэнэбат : Тийм.

Мөнхбат: Аа тэр 1989-1993 оны хооронд гэр дугантай байж тийм ээ?

Эрдэнэбат: Гэр дуган, гэр дугантай байсан.

Мөнхбат: Гэр дуган нь яасан энэ сүмийн төв дээрээ байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Эрдэнэбат: Энд хийдийнхээ урд талд.

Мөнхбат: За тэгээд мэдээж тухайн үеийн одоогоос 100-аад жилийн тэртээх маш баялаг түүхтэй, шашин номын өргөн их том уламжлал бүхий энэ хүрээ хийдийг залгаж ирсэн ийм сайхан дуган байна аа, танай энэ хийд. Тэгэхээр одоо ямар шүтээн сахиустай байна?

Эрдэнэбат: Жамсран шүтээнтэй. Улаан Жамсран, улаан сахиус.

Мөнхбат: За тэгэхээр энэ хийд анх байгуулагдахад одоо ямар ямар хүмүүс чухал үүрэг гүйцэтгэсэн юм бол, хэн хэн гэдэг хүний санаачилгаар, за ямар ч байсан сүсэгтэн олны байна, тийм ээ. Тэгэхээр гол гол хүмүүс гээд нэр байна, тийм ээ?

Эрдэнэбат: Гомбохоо гээд нэг лам бий дээ. Ёндонгомбо гээд.

Мөнхбат: Ёндонгомбо гэж, одоо энд амьд уу, үгүй юу?

Эрдэнэбат: Байхгүй. Одоо ер нь хөгшчүүл бүгд байхгүй ш дээ.

Мөнхбат: Аа тэгээд тэр хүн яасан юм, энэ байсан юм уу, Улаанбаатар, Гандан манданд суудаг лам байсан юм уу?

Эрдэнэбат: Эндээ сууж байсан юм.

Мөнхбат: Яг эндээ одоо энэ Рашаантын хүрээнд шавилж сууж байсан юм уу?

Эрдэнэбат: Шавилж сууж байсан. Олон хүн байгаа л даа, Цэрэн гуай энэ тэр гээд. Хөгшчүүл бол.

Мөнхбат: Аа тэр хүн бол одоо нэлээн гол үүрэг гүйцэтгэсэн?

Эрдэнэбат: Тийм.

Мөнхбат: Өөр одоо нутаг орон нутгаас гарсан бизнесмэн байна, сум орон нутгийн одоо удирдлагууд төр захиргааны байгууллага, сүсэгтэн олон ер нь энэ дээр яаж хамтарч ажилласан бэ, одоо сонссон мэдсэн юм байна уу, энэ дээр?

Эрдэнэбат: Аа тэр тухайн үед чинь одоо бараг л нэгдэл шахуу байж байгаад л яасан юм байгаа биз. Тэр наян есөн оны тэр үед чинь дандаа л хандив, ард түмний хандиваар. Тэр нэг их бизнес энэ тэр орсон юм байхгүй. Нутгийн зөвлөлөөс нэг бага хэмжээ л гарсан байх. Дандаа л ард түмний хандиваар, малчид энэ хөдөрмөрчдийн хандиваар боссон.

Мөнхбат: Одоо ямар хурал хурж байна, за мэдээж одоо өөрийн чинь ингээд лам нарын тоо моо энэ тэрийг ингээд хараад үзэхээр цагийн хуралтай л байна уу, одоо ямар хуралтай байна? Онцгой дүйчэн өдрүүдэд хурж байна уу, байнгын хурал одоо өглөө цогчиноо уншиж байна уу, яаж байна энэ ямархуу хуралтай байна?

Мөнхбат: Лам гэх юм байхгүй ш дээ, одоо манайх чинь одоо. Баасанжав гуай гээд нэг настайтавтар хүн бий. Сүүлд лам болсон. Тэгээд ерөөсөө байхгүй, нэг цагаан сарын чоймпорлин хурал, дүйчэн хурлаар л голчлон хурна даа. Тэгээд ерөөсөө лам гэх юм байхгүй, манайх чинь.

Мөнхбат: Ерөөсөө билгийн тооллын эхний арван таван хоногт хурна гэсэн үг үү?

Эрдэнэбат: Арван таван, цагаан сарын шинийн арван таван хүртэл хурна. Тэгээд л найман, арван таванд бол бурхан багшийн их дүйчэн өдөр энэ тэр гээд л.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Ямар ямар хурлууд хурдаг вэ, тэр хурлуудынхаа нэрийг хэл дээ, ном уншдаг хурлуудынхаа нэрийг?

Эрдэнэбат :За манайх чинь одоо тэгээд нэг ганц хүн чинь одоо хурал хурна гэж байх уу даа.

Мөнхбат: Уншлаганы номнуудаа?

Эрдэнэбат :Уншлаганыхаа номнууд ч яахав, тэгээд цогчингоо хурчихна. Дан ерөөл мөрөөл айлдаад л тэгээд л яачихна даа.Ерөөл айлдаад л . Тэгээд уул нь энэ цагаан сар мар, овоо тахилга , зуны тэр бурхан багшийн дүйчэн өдөр энэ тэрээр хотоос тэр нутгийн лам нар их ирдэг юм аа.Ирэхээрээ тэгээд дандаа Жамсран сахиус энэ тэрээ тахичихна. Жамсрангаа тахичихна, манал хурчихна. Ер нь голцуу л манай сүм манал хурна даа.Ганцаараа болохоор.

Мөнхбат: Жандагийн хурал бол байх уу, байна биз?

Эрдэнэбат: Жандаг байлгүй яахав. Ер нь тэгээд л өдрийн уншлага гэхээр голцуу жандаг л байгаа юм чинь, дандаа жандаг л хурж байгаа юм чинь.

Мөнхбат: Одоо энэ дуганаа тордох тийм ээ, хэвийн ажиллагааг нь цааш нь үргэлжлүүлэх за тэгээд одоо тохижуулах гэдэг юм уу тийм ээ, ийм байдалд хүргэхэд одоо мэдээж мөнгө цаасын хэрэгтэй тийм ээ. Тэгэхээр одоо ер нь өөрөө ганцаараа энэ том дуганд, энэ их том хүрээний шинэ цагийн дүр төрхийг авч явж байгаа, энэ дуганыг ингээд хариуцаад байж байгаа хүний хувьд энэ санхүүгийн тал дээр одоо яаж байна аа, яаж болж байна аа?

Эрдэнэбат :Санхүүгийн тал ч ер нь бэрх дээ. Одоо харин энэ нөгөө гэгээнтний дүү нь эсэргүүний суварга энэ тэр босгох гээд хотоос нутгийн зөвлөл сая баахан хандив авсан. Одоо энэ хашаа машаагийн нь харин өнөөдөр энэ хэмжилт хийнэ гэсэн хийсэнгүй ш дээ.Тэгээд л өнөөдрөөс авахуулаад л энэ хашаа машаа солигдох байх. Одоо нутгийн зөвлөлийнхөн нутгийн лам нар энэ тэр олон лам ирэх байх. Энэ баяраас өмнө одоо хорин гурванд гээд л лам нар одоо суварганыхаа суурийг босгочихсон байгаа.Одоо шавыг нь тавьчихсан байгаа. Тэгээд суурийг нь босгоод л тэгээд.

Мөнхбат:Энэ одоо энэ үйл ажиллагаа явуулж байгаа дуганы хэмжээ хэд вэ? Урт өргөний хэмжээ нь хэдтэй байдаг юм?

Эрдэнэбат: Хааш хаашаага л яг арав, тийм. Метр квадрат л даа.

Мөнхбат: за цаашид лам нартай болж , ядаж нэг өөрөөсөө гадна гурван ламтай болмоор тийм ээ, одоо нэг хоёр ламтай юм байна ш дээ. Өөртэйгээ нийлээд тийм ээ. Дахиад нэг хоёр ламтай болоод ингээд одоо хурал номынхоо үйл ажиллагааг тогтмолжуулах талаар та ер нь ямар бодлого баримталж байна вэ?

Эрдэнэбат: Уул нь ч одоо манайх лам нар их ш дээ. Хөдөөний улсууд, хөдөө болохоор чинь лам нар чинь голцуу хот луугаа л явчих юм байна ш дээ. Хот мот, Энэтхэг лүүгээ. Манай уул нь Рашаантын лам нар бол, яг гарал Рашаантаас гарсан лам нар бол маш олон байгаа ш дээ. Дашчойлин , Гандантэгчилэн хийд тэгээд Энэтхэгт чинь хоёр бий. Тэд нар төгсөж ирэхээрээ болох байх аа, тэгээд.

Мөнхбат: 1993 онд байгуулагдсан гэж байна. Ерэн гурван оноос хойш энэ шинэ байгуулагдсан Дашдаржаалин хийд өнгөрсөн арван дөрөв , таван жилийн хугацаанд ямар ямар түүхэн үйл явдал тохиолдсон бэ, одоо жишээ

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нь энд тэндхийн томоохон хамба хутагт, хувилгаадүүд морилж залрах ч байдаг юм уу, одоо гадна дотноос томоохон хөлгөн их судруудыг залах ч байдаг юм уу Энэтхэг, Төвдөөс тийм ээ. За өөр одоо юу байдаг юм. Бурхан шүтээн сахиус одоо залах ч байдаг юм уу, эсвэл одоо лам нарын бодлого дээр боловсон хүчнийг бэлтгэх талаар танай энд шавилж сууж байсан тэр банди нараас бурхан шашны их сургууль, за мөн одоо Энэтхэг Төвд рүү сургуульд цол хэргэм дээшлүүлэх гээд явдаг ч байдаг юм уу. Имй одоо түүхэнд тэмдэглэх үйл явдал юу болсон юм бол оо, энэ арван таван жилд байгуулагдсанаасаа хойш бол?

Эрдэнэбат: Ноднин чинь Даравбандид гэгээний 120 жилийн ой болсон.

Мөнхбат: Аа тийм, бүр төрийн хэмжээнд авч үзсэн ш дээ?

Эрдэнэбат :Тэгээд хойно тэр бурхад юуг нь гэгээнтний газар нь тэр лагшингийн суварга энэ тэр босгосон.

Мөнхбат: Аа унасан газар нь?

Эрдэнэбат : Тийм, лагшингийн суварга босгосон.

Мөнхбат: Эндээс хэд орчим км газар вэ?

Эрдэнэбат: Эндээс ч одоо бараг далаад км юм уу даа.Архангайн нутаг ш дээ, бараг. Бух чулуут руугаа , яг төрсөн газар нь.

Мөнхбат: Хэддүгээр багийн нутаг вэ?

Эрдэнэбат: Архангайн Цэцэрлэгийн нутаг.

Мөнхбат: Тухайн үедээ энэ Рашаантын нутаг байсан?

Эрдэнэбат: Рашаантын, манай хошуу л байхгүй юу, тэгээд энэ юугаар авчихсан.Салчихсан.

Мөнхбат: За өөр ?

Эрдэнэбат: Одоо чинь манайхаас хоёр хүүхэд Энэтхэгт, хоёр хүүхэд Энэтхэгт, бага хүүхэд шавилж байгаа.

Мөнхбат: Хэдэн нас орчмын хүүхдүүд вэ?

Эрдэнэбат: Одоо арван гурав муравтай байна уу.

Мөнхбат: Одоо яг энэ дуганд, энэ хийдэд хэдэн жил шавилаад явсан хүүхдүүд юм, тэд нар? Ном заалгаад явсан хүүхдүүд юм?

Эрдэнэбат: Тэд нар бол шууд юунаасаа л , бага ангиасаа л хот руу яваад л. Анхнаасаа бүр энэ хотод л нэг хагас жил бага сургуульд заалгаад л тэгээд л яачихаж байгаа юм Багаасаа сурч байгаа юм.

Мөнхбат :За өөр ямар ямар үйл явдлууд тохиолдсон бэ?

Эрдэнэбат: За өөр ч нэг айхтар болсон юм байхгүй. Ноднин чинь бас нөгөө хошуу ноёны ой болж хүрэн дээрээс хотоос лам нар ирж хурал хурсан.

Мөнхбат :Одоо Мэргэн гүн Гомбожав гуайн?

Эрдэнэбат : Тийм, Гомбожав гуайн, ноднин зуун жилийн ой.

Мөнхбат: Тэрүүгээр ямар үйл явдал болсон гэнэ ээ, энэ хүрээ хийд дээр?

Эрдэнэбат: Хүрэн дээр Мөнх-Эрдэнэ энэ тэр гээд хотоос лам нар ирж хурал хурсан. Уул нь ч лам нар их ирдэг юм аа. Манайх зуны цагт бол сайхан сайхан хурал хурдаг юм.Хотод чинь манайх чинь одоо Дашчойлинд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гаралтай Мөнх-Эрдэнэ лам байна. Ганданд чинь одоо зурхайн дацанд чинь манай Рашаантын хоёр ч лам бий. Төмөр замд бий.Одоо чинь Цэрэндорж гээд нэг өвгөн лам бий дээ. Төмөр замд бий.

Мөнхбат: За энэ Дашдаржаалин хийд маань ер нь энэ бүс нутагтаа алдартай байсан тэр хүрээ хийдийг залгамжилж гарч ирсэн орчин цагийн хийд. Тэгэхээр тэр одоо өмнөх байсан хүрээ хийдийн бурхан тахил ном судраас энэ тэрээс одоо ингэж залгамжлагдаж ирсэн ийм эд өлгийн зүйлс байна үү?

Эрдэнэбат: Байлгүй яахав. Одоо энэ гэгээнтний сэнтий байна ш дээ.

Мөнхбат: Өө аль сэнтий?

Эрдэнэбат: Тэр байна ш дээ. Тэр одоо гэгээнтний өөрийнх нь заларч байсан сэнтий.

Мөнхбат: Өө бүр тэрэн дээр тавьчихсан байгаа тийм ээ?

Эрдэнэбат: Тийм, тэр сэнтий ширээтэйгээ. Тэр өөрөө бүр тэр Даравбандид гэгээн чинь, сүүлийн Даравбандид гэгээн чинь заларч байсан. Өөрийнх нь хэрэглэж байсан.

Мөнхбат: Тэр дээд талд нь байгаа өөрийнх нь хөрөг нь мөн үү?

Эрдэнэбат: Хөрөг нь гэгээнтний хөрөг байхгүй юу. Даравбандид гэгээнтний хөрөг.

Мөнхбат: Зургийг нь авахыг нь бол зөвшөөрнө биз дээ, фото зургийг нь?

Эрдэнэбат: Зөвшөөрөлгүй яахав, зөвшөөрөлгүй яахав.Даравбандид гэгээний угаасаа тэнд өрөөтэй байгаа юм чинь.

Мөнхбат :За мэдээж тэгээд бурхан номны юмнууд бол зөндөө л байгаа биз дээ?

Эрдэнэбат: Байлгүй яахав, ном судар бол байлгүй яахав.

Мөнхбат: Байгуулагдсан цагаас нь эхлээд л энэ нутгийн сүсэгтэн олон бол ихэнх нь хадгалж байсан, гэртээ хадгалагдаж байсан юмнуудаа өргөл барьцаар их өгсөн биз, тийм ээ?

Эрдэнэбат: Тийм.

Мөнхбат :За ингээд бид нар Эрдэнэбат ламтай товчхон ярилцлага хийсэн. За ингээд Эрдэнэбат ламын ярилцлага дээр бид нар бас дэлгэрүүлээд ингээд шинэ сүм хийдийн маягтаа дараа нь хөтөлнө өө. За ингээд энэ ярилцлагыг өгсөн таньд баярлалаа. Таны одоо энэ Даравбандид хэмээх халхын шарын шашны нэр алдартай томоохон хүний үүслийг залгамжилж , түүний байгуулж анх түүхийг нь эхлүүлж байсан энэ хүрээг одоо хэдийгээр жар далаад жил тасарсан ч гэсэн дахиад сайн цагийн одоо энэ цагийн эхэн өнгөн дээр байгуулаад одоо ингээд бурхан тахилыг нь таслахгүй, зулыг нь таслахгүй, буян номын үйл ажиллагааг нь үргэлжлүүлж энэ нутгийн сүсэгтэн олонд үйлчилж байгаа таны буяны цагаан мөр өлзийтэй байх болтугай гэж хүсье. Таньд баярлалаа.